



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 362

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 54,900,000.00 (тавин дөрвөн сая есөн зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 41,175,000 (дөчин нэгэн сая нэг зуун далан таван мянга) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Зоригт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132002574

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2022 оны ... дугаар сарын ... өдрийн  
 ... дугаар тогтоолын хавсралт

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМАНД  
 БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Автомашины нэр, улсын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Соната-8, улсын дугаар УБҮ 06-25	2015/2016	54,900,000.00	41,175,000.00	13,725,000.00
<b>Нийт дүн</b>			<b>54,900,000.00</b>	<b>41,175,000.00</b>	<b>13,725,000.00</b>
			(тавин дөрвөн сая есөн зуун мянга)	(дөчин нэгэн сая нэг зуун далан таван мянга)	(арван гурван сая долоон зуун хорин таван мянга)